



ДААТГАЛ
1994 ОНД БАЙГУУЛАГДАВ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН 2023

Хүчтэй. Хамтдаа.





ТАНИЛЦУУЛГА

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	02
Компанийн танилцуулга	03
Тайлангийн тухай	04

БАЙГАЛЬ ОРЧИН

Байгаль орчны эрсдэл	11
Байгалийн гамшгийн хамгаалалт	12
Хариуцлага	14

ЗАСАГЛАЛ

Компанийн засаглал	27
Ёс зүй ба комплаенс	28
Эрсдэлийн удирдлага	30
Мэдээллийн аюулгүй байдал	31

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал	06
БОНЗ-ын тогтолцоо	08
Бидний оролцоо	09

НИЙГЭМ

Хариуцлагатай даатгагч	17
Хариуцлагатай ажил олгогч	22
Хариуцлагатай хувьцаат компани	24
Хариуцлагатай хамтын ажиллагаа	25

ХАВСРАЛТ

SASB удирдамж	33
НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн зорилгууд	36
БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж	37

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Эрхэм хүндэт нийт хувьцаа эзэмшигч, даатгуулагч, түнш, төрийн болон төрийн бус байгууллагууд, үе үеийн нийт хамтран зүтгэгч та бүхэндээ,

Ард даатгал ХК үүсгэн байгуулагдаж хөгжсөний 30 жилийн ойг тохиолдуулан Тогтвортой хөгжлийн анхны тайлангаа та бүхэнд танилцуулж буйдаа баяртай байна. Бид тогтвортой хөгжлийн зорилтуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлснээр уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, нийгмийн тэгш бус байдлаас үүдэлтэй сорилтуудыг шийдвэрлэх зайлшгүй шаардлага байгааг тэмдэглэхийг зорьсон юм. Хэдийгээр эдгээр сорилтууд нь нэг байгууллагын хувьд дангаар шийдвэрлэхэд хэтийдсэн ажил хэдий ч бид бүхэн хамтын ажиллагаа, тогтвортой хөгжилд чиглэсэн нөлөөллийн олон янз байдлаар эрсдэлийг бууруулж тогтвортой хөгжилд чиглэж чадна гэж үзэж байна.

Бид бизнесийн үйл ажиллагаанаас гадна компанийн дотоод үйл ажиллагааг байгаль орчинд ээлтэй байдлаар явуулах, ажилтнууддаа байгаль орчин, нийгэм, засаглалын талаарх ойлголт, мэдээллийг хүргэхэд чиглэсэн сургалтуудыг хийсээр байна. Мөн Ард даатгал нь хувьцаат компани болохын хувьд засаглалын зохистой бөгөөд тогтвортой байдлыг хадгалж, ёс зүйн дээд хэм хэмжээг баримтлан хувьцаа эзэмшигч, түншлэгч байгууллагууддаа ил тод, үнэн зөв, нээлттэй мэдээллийг хүргэх үүргээ ямагт биелүүлсээр байх болно.

Тогтвортой хөгжил бол хүрэх цэг бус явах зам бөгөөд энэхүү хөгжлийн замаар даатгалын салбарт түүчээлэн ажиллаж буй нийт хамт олон, хамтын ажиллагаа нэгдмэл хүсэл зориг бүхий харилцагч, хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигч нартаа гүнээ талархал илэрхийлье. Бид БОНЗ-ийн сайн засаглалыг хэрэгжүүлснээр, ээлтэй нийгэм, ногоон ирээдүйг бүтээхийн төлөө итгэл төгс түүчээлэх болно.

Хүндэтгэсэн,

Ард Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал

Г.Цогбадрах



Компанийн танилцуулга

Ард даатгал ХК нь 1994 онд байгуулагдсан бөгөөд өдгөө ердийн даатгалын 50 гаруй бүтээгдэхүүнийг хувь хүн болон байгууллагын харилцагчдад санал болгож байна. 2018 оны 10 сарын 1-ний өдрөөс Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаагаа олон нийтэд арилжиж эхэлсэн бөгөөд анхдагч зах зээлийн арилжаанд нийт 1,359 хөрөнгө оруулагч оролцсон бол, 2023 оны байдлаар 10,000 орчим буюу Монголын хамгийн олон хөрөнгө оруулагчтай нээлттэй даатгалын компани болсон байна.



Эрхэм зорилго

Даатгуулагчийн хэрэгцээнд тохируулсан, ёс зүйг баримталсан, зохистой даатгалын үйлчилгээг бид үзүүлнэ.



Алсын хараа

Даатгуулагчдын ирээдүйдээ итгэлтэй, амар тайван байдлыг хангасан, тэднийг амжилтад хөтөлсөн даатгалын үйлчилгээ үзүүлэгч, шилдэг даатгалын компани болох.



Үнэт зүйл

Эрсдэлийг даатгуулж, даатгах нь амжилтын эхлэл юм.

Нийт хөрөнгө

44.2 тэрбум төгрөг

Зах зээлд эзлэх хувь

9.4%

Цэвэр ашиг

3.2 тэрбум төгрөг

Нөхөн төлбөр

14.1 тэрбум төгрөг

Даатгуулагчийн тоо

243,000

Тайлангийн тухай

Монгол улсын даатгалын салбараас олон нийт, хөрөнгө оруулагчид болон бусад оролцогч талуудад зориулан бэлтгэсэн анхны “Тогтвортой хөгжлийн тайлан”-г та бүхэнд хүргэж байгаадаа манай хамт олон баяртай байна. Ард даатгал ХК-ийн “Тогтвортой хөгжлийн тайлан 2023” нь байгаль орчин, нийгэм, засаглал болон “Тогтвортой хөгжлийн” зорилгуудад хувь нэмэр оруулж буй компанийн үндсэн үйл ажиллагаа, стратеги, бодлого болон ирээдүйд хийхээр төлөвлөж буй ажлуудыг багтаасан болно.

Тайланд дурдсан үйл ажиллагаа болон санхүүгийн тоон үзүүлэлтүүд, мэдээллийг 2023 оны жилийн тайлан болон аудитлагдсан тайлангаас харах боломжтой. Тайлантай холбоотой асуулт, санал хүсэлт, сэтгэгдлийг info@arddaatgal.mn хаягаар илгээнэ үү.

Тайлангийн хамрах хүрээ

Энэхүү тайланд БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамж, НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн зорилгууд болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын (IFRS) нэг хэсэг болох Sustainability Accounting Standards Board (SASB)-оос гаргасан даатгалын салбарын удирдамжийг ашигласан болно. SASB, БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамж, НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн зорилгуудад нийцүүлсэн дэлгэрэнгүй тодруулгыг Хавсралтаас үзнэ үү.





01 Тогтвортой хөгжил



Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал

БОНЗ-ын тогтолцоо

Бидний оролцоо

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал

Ард даатгал ХК нь үндсэн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ болон өдөр тутмын дотоод үйл ажиллагаагаараа дамжуулан тогтвортой хөгжлийн зорилгуудад хувь нэмрээ оруулж, байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэл ба боломжуудыг тодорхойлон бизнесийн бүхий л оролцогч талуудад ээлтэй, ашиг тустай ажиллахаар зорьдог. Үүний нэгэн илрэл нь бидний үйл ажиллагаандаа мөрддөг зарчмууд болон үзэл баримтлал юм.

Бидний үйл ажиллагааны зарчим нь CIRCLE буюу ХҮРД гэсэн утгатай дараах бүтэцтэй.

Customer

Integrity

Responsibility

Collaboration

Long-term
perspectiveExcellence
in service

C

I

R

C

L

E

Даатгуулагчаа цаг
ямагт хүндэтгэсэн

Итгэл хүлээж, ёс зүйг
баримталсан

Хариуцлагатай
даатгалын үйлчилгээг
санал болгосон

Эрсдэлийн удирдлагын
зохистой бодлогыг
хамтран боловсруулан,
болзошгүй эрсдэлээс
ямагт урьдчилан
сэргийлдэг

Урт хугацааны
түншлэлийн харилцааг
эрхэмлэж, оролцогч
талуудыг амжилтад
хөтөлсөн

Мэргэжлийн түвшний
даатгалын хамгаалалт,
үйлчилгээг
даатгуулагчдаа санал
болгосон

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал

Тогтвортой хөгжил ба байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд бид үйл ажиллагаандаа дараах амлалтуудыг харилцагчид, хөрөнгө оруулагчид, хамт олон болон олон нийтийн өмнө хүлээн ажиллаж байна.

Ирээдүй хойч үеийнхээ боломжийг үгүй хийхгүйгээр өнөөдрийн хэрэгцээгээ хангах зорилготой НҮБ-аас гаргасан тогтвортой хөгжлийн зорилгуудаас дараах 3 зорилгод голлон анхаарч хувь нэмэр оруулахаар сонгон ажиллаж байна. Эдгээр зорилгууд нь санхүү, даатгалын салбар дах бидний 30 жилийн туршлага болон цаашдын алсын хараатай нийцэж байгаа юм.



Чанартай
боловсролыг
дэмжих



Зохистой хөдөлмөр
ба эдийн засгийн
өсөлтийг дэмжих



Уур амьсгалын
өөрчлөлтийн үр
нөлөөг багасгах

Манай хамт олон байгаль орчин, нийгэм, засаглалын тогтолцооны хүрээнд дараах зүйлсийг эрхэмлэн ажилладаг.

Шударга байж, хариуцсан ажилдаа тууштай, хариуцлагатай

Даатгуулагч болон хамт олноо хүндэлсэн найрсаг

Үргэлж суралцагч, санаачлагатай

Аливаа асуудлыг түргэн шуурхай зохистой шийдвэрлэдэг

Ахмадыг хүндэлж, залуусыг сургадаг

Гэр бүлээ асран хамгаалагч, ажилсаг нэгэн байна

Байгаль орчин, нийгэм, засаглалын тогтолцоо

БАЙГАЛЬ ОРЧИН

- Үйл ажиллагаагаараа дамжуулан байгаль орчинд аливаа сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
- Бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан байгалийн гамшигаас үүссэн хохиролд санхүүгийн хамгаалалт үзүүлнэ.
- Байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй төслүүдэд хөрөнгө оруулна.

НИЙГЭМ

- Хүний эрхийг дээдэлж, бүхий л оролцогч талуудтай эрх тэгш, ил тод зарчмыг баримтлан ажиллана.
- Аливаа ялгаварлан гадуурхалтыг эсэргүүцэж, хүртээмжгүй байдлыг бууруулна.
- Осол эндэгдлийг бууруулах, аюулгүй байдлыг сахин хамгаалах, эрсдэл, даатгалын мэдлэгийг түгээн дэлгэрүүлнэ.

ЗАСАГЛАЛ

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэж, авилга, хээл хахуулийг зөвшөөрөхгүй.
- Компанийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод тайлагнаж, оролцогч талуудын өмнө өндөр хариуцлага хүлээнэ.
- Бизнесийн ёс зүйг эрхэмлэн, хууль дүрэм, журамд нийцтэйгээр тасралтгүй өсөлтийг бий болгоно.

Тогтвортой хөгжил ба бидний оролцоо



4 ЧАНАРТАЙ
БОЛОВСРОЛЫГ
ДЭМЖИХ

Санхүү Эдийн Засгийн Их Сургуультай хамтран “Даатгалын зах зээлийн сорилт ба шийдэл” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, ерөнхий ивээн тэтгэгчээр оролцов. Оюутан залуусын судалгаа, шинжилгээний ажлыг дэмжин мөнгөн шагнал олгов.

Монголын Хөлбөмбөгийн холбоотой хамтран ажиллаж олон улсын тэмцээнд оролцож буй өсвөрийн хөлбөмбөгийн тамирчдыг даатган хамтран ажилласан.

“Даатгал бидний амьдралд” сургалтыг тогтмол зохион байгуулж, 2023 онд 21 аймгийн 63 ерөнхий боловсролын сургуулийн, бага бүлгийн 25,200 сурагчдад эрсдэл, даатгалын суурь боловсрол олгох сургалт орлоо.



8 ЗОХИСТОЙ ХАДЛАМЖ
БА ЭДИЙН ЗАСГИЙН
БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ

Ажилтнууддаа уян хатан, сэтгэл ханамжтай ажлын байрыг бүрдүүлсээр ирсэн бөгөөд хүний нөөцийн тогтворжилтын коэффициент 85.9 хувьтай байгаа нь манай компанийн ажиллагсад харьцангуй тогтвор суурьшилтай ажиллаж байгааг илтгэдэг.

2023 онд нийт хөрөнгийн хэмжээ, хураамжийн орлого, ашигт ажиллагаа зэрэг үзүүлэлтээр топ 3 даатгалын компанид багтаж, нийт хөрөнгөөр салбарын 9.4 хувийг эзэлж байна. Мөн жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийн орлогоор салбартаа тэргүүлж, нийт нөхөн төлбөрийн тохиолдлын 52 хувийг компанийн хохирол баталгаажуулалтаар шийдвэрлэв.

2018 онд олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноос хойш манай компанид хөрөнгө оруулагчдын тоо 7 дахин өсөж, ойролцоогоор 10,000 хувьцаа эзэмшигчтэй буюу салбартаа хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй даатгалын компани болоод байна.



13 УУРАМСТАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР
НӨЛӨГ БАГАСГАХ

Байгаль дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор гэнэтийн гамшгаас үүдэлтэй ихээхэн хэмжээний хохирлоос урьдчилан сэргийлэх санхүүгийн хамгаалалт бүхий “Малын индексжүүлсэн даатгал”, “Газар тариалангийн даатгал” болон ялгаатай 24 даатгалын бүтээгдэхүүнд ган, зуд, үер, шороон шуурга гэх мэт байгалийн гамшигт үзэгдлийн эрсдэлийг даатгаж байна.

Цаасны хэрэглээг багасгах, гэрээ байгуулахтай холбоотой оролцогч талуудын цаг хугацаа, санхүүгийн нөөцийг хэмнэх давуу тал бүхий цахим даатгалыг хөгжүүлж, төрийн байгууллагаар дамжуулан даатгалын үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлээд байна. Мөн түүнчлэн дотоод үйл ажиллагааны системд цогц шинэчлэлтийг хийж, тасралтгүй хөгжүүлж байгаагийн үр дүнд нийт үйл ажиллагааны 70 хувийг автоматжуулан цаасны хэрэглээнээс татгалзаж байна.



02 Байгаль орчин

Байгаль орчны эрсдэл

Байгалийн гамшгийн хамгаалалт

Байгалиа хамгаалах бидний хариуцлага

Уур амьсгалын эрсдэлүүд

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт нь бүх нийтийн өмнө тулгамдаж буй асуудал болж үүнээс шалтгаалсан байгалийн гамшгийн давтамж нэмэгдэж байгаа өнөө үед бид дараах эрсдэлүүдийг даатгаж харилцагчдаа гэнэтийн санхүүгийн эрсдэлээс хамгаалж байна. Эдгээр эрсдэлүүдийг 9 даатгалын төрлийн, 24 даатгалын бүтээгдэхүүнүүдийг харилцагчдаа санал болгож байна.

Байгалийн эрсдэл

Хүчит салхи, цас, цасан ба шороон шуурга, ган зуд, цочир хүйтрэлт, үер, газар хөдлөлт, хөрс, чулууны нуралт, овойлт, цөмрөлт, хөрсний усны түвшин, хүйтэн бороо, аянга, мөндөр, хяруу, ой хээрийн түймэр, шаварт унаж шигдэх, хөлдөх, осгох, наранд цохиулах зэрэг эрсдэл

Галын эрсдэл

Гал, түймэр, бүх төрлийн тэсрэлт, дэлбэрэлт



Байгалийн гамшгийн хамгаалалт

Үерийн эсрэг хамгаалалт

2023 оны зун Улаанбаатар хотод их хэмжээний бороо орж, үерийн эрсдэл үүссэн. Олон айл өрхүүд өмч хөрөнгөөрөө хохирсон тохиолдлууд гарсан бөгөөд манай байгууллага нь хөрөнгийн даатгалын хохиролд давхар даатгагчтай хамтран хохирлыг түргэн шуурхай барагдуулахад дэмжлэг болон ажилласан.

Үерийн хохиролд

1 тэрбум төгрөг

нөхөн төлбөр олгов.

Цар тахлын эсрэг хамгаалалт

Дэлхий нийтийг хамарсан аливаа тахал, өвчлөлийг даатгах нь ердийн даатгалын компаниудын хувьд даатгах боломжгүй, системийн эрсдэлд тооцогддог. 2019 - 2021 онуудад тохиолдсон Ковид-19 цар тахлын эсрэг улс, орнууд хамтдаа тэмцэж байх үед Ард даатгал ХК нь 500 сая төгрөгийн нөхөн төлбөрийг харилцагчиддаа олгосон бөгөөд аяллын даатгалдаа Ковид-19 цар тахлын эрсдэлийг оруулав.



Газар тариалангийн хамгаалалт

2017 онд манай компани Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал ХК-тай хамтран газар тариалангийн даатгалыг Монгол улсын даатгалын зах зээлд анх удаа хэрэгжүүлэх ажилд амжилттай оролцсон. Энэхүү даатгалын хүрээнд нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалын бүтээгдэхүүнийг Сэлэнгэ аймгийн 9 сум, Төв аймгийн 1 сум, Булган болон Дархан-Уул аймгийн 8 суманд санал болгож 4 аж ахуйн нэгжид 211 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон.

Байгалийн гамшгийн хамгаалалт

Зуд, цасан шуургын эсрэг хамгаалалт

Монгол улсын уламжлалт мал аж ахуйн салбарт тохиолддог байгаль, цаг уурын эрс тэс нөхцөл болон гэнэтийн гамшгаас үүдэлтэй ихээхэн хэмжээний хохирлоос урьдчилан сэргийлж малчдын амьжиргааны эх үүсвэр болсон мал сүргийг хамгаалах зорилготой **“Малын индексжүүлсэн даатгал”**-ыг иргэддээ санал болгож байна.

217 сая төгрөг

Хураамжийн орлого

449 сая төгрөг

Нөхөн төлбөр

Энэхүү даатгалын хүрээнд доор дурдсан хохирлоос үүдэн гарах хорогдлыг нөхөн олгодог.

- Зуд, байгалийн гамшигт үзэгдэл
- Өвчин эмгэг
- Чоно нохойд баригдах
- Хулгайд алдсан, сураггүй алга болсон



Байгалиа хамгаалах бидний хариуцлага

Ногоон байгууламж, мод

Манай компани хүрээлэн буй байгаль орчноо хамгаалах үйл ажиллагааг компанийн нийгмийн хариуцлагын томоохон хэсэг гэж үздэг бөгөөд 2013 оноос эхлэн жил бүр хамт олноороо мод тарьдаг уламжлалтай болсноос хойш 2023 оны байдлаар Хамрын хийд, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Үндэсний соёл амралтын хүрээлэн, Инчьеон Мөрөөдлийн төгөл зэрэг байршлуудад ойролцоогоор 1000 орчим мод тарьж, “Тэрбум мод - Үндэсний хөтөлбөр”-т хувь нэмрээ оруулаад байна. Жил бүрийн зохион байгуулалт ялгаатай явагддаг бөгөөд зарим жил салбарын компаниудтай хамтран оролцдог.



10 жилийн хугацаанд нийт

1000 гаруй мод

хамт олноороо тарьсан.



Байгалиа хамгаалах бидний хариуцлага

Цахим даатгал

2022 оноос даатгалын үндсэн үйл ажиллагаануудыг цахимжуулахаар манай хамт олон эрчимтэй ажиллаж эхэлсэн бөгөөд 2023 оноос Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээг цахимаар хийдэг болж Ард апп болон “Авто тээврийн үндэсний төв”-ийн autobox аппликейшн, Үндэсний дата төвтэй хамтран цаг алдалгүй, түргэн шуурхай даатгалын үйлчилгээ авах боломжийг олгож эхэлсэн.

Мөн түүнчлэн жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, тээврийн хэрэгсэл, эрүүл мэнд, зээлдэгчийн барьцаа хөрөнгө, орон сууц эзэмшигчийн болон гадаад ачаа тээврийн даатгал гэсэн нийт 6 бүтээгдэхүүний нөхөн төлбөрийн материалыг цахимаар хүлээн авч байна.

Цаасны хэрэглээг

50% бууруулав.

2023 оноос цахим даатгалын үйлчилгээг үйл ажиллагаандаа 100 хувь нэвтрүүлснээр 2022 онтой харьцуулахад цаасны хэрэглээ 50 хувиар буурсан үр дүнд хүрсэн ба мөн принтерийн хор, архивлах цаас, архивын баримт устгалаас бий болдог агаарын бохирдлыг бууруулах эерэг нөлөөллүүд гарсан байна.





03 Нийгэм



Хариуцлагатай даатгагч

Хариуцлагатай ажил олгогч

Хариуцлагатай хувьцаат компани

Хариуцлагатай хамтын ажиллагаа

Даатгалын бүтээгдэхүүн хөгжүүлэлт

2023 оны байдлаар бидний санал болгож буй 50 гаруй даатгалын бүтээгдэхүүнээс Тогтвортой хөгжлийн зорилгын эрүүл мэндийг дэмжих, ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих гэсэн 3, 11-р зорилгуудад хувь нэмэр оруулж буй “Гэнэтийн осол, эмчилгээний даатгал”-ыг энэ удаагийн тайлангаар онцолж байна. Энэ төрлийн даатгалд дараах бүтээгдэхүүнүүд хамаардаг.



Манай харилцагчид БНХАУ, Солонгос, Япон, Тайланд, Монгол, Австрали, Герман, Швед, Швейцарь зэрэг улсуудын сүлжээ эмнэлгүүдээр үйлчлүүлж даатгалын шууд төлбөрийн үйлчилгээг авсан байна. **2023 онд эрүүл мэнд болон гэнэтийн ослын даатгалаар олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг доор харуулав.**

Нийт 2,899 нэхэмжлэлд

2.2 тэрбум төгрөг

нөхөн төлбөрийг олгов.

Эрүүл мэндийн даатгалын ач холбогдол, идээдүйд учирч болзошгүй эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээлэл, сургалтуудыг мэргэжлийн эмч нартай хамтран зохион байгууллаа.

100 байгууллагын

4,500 ажилтан

сургалтад хамрагдав.

Даатгалын андеррайтинг

Сэргээгдэх эрчим хүч

Бид байгаль дэлхийд ээлтэй, нар, салхи гэх мэт сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг бий болгож буй компаниудтай хамтран ажиллаж, хөрөнгө, бизнесийн тасалдал болон хариуцлагын даатгалуудыг хөнгөлөлттэй хураамжийн тооцоололд үндэслэн даатгаж байна.

2023 оны байдлаар нийт даатгалын хураамжийн 0.05 хувь буюу 1 тэрбум төгрөгийг сэргээгдэх эрчим хүчний компанийн даатгал эзэлж байна. Бид цаашдаа байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэж буй компаниудыг хөнгөлөлттэй үнээр даатгаж, нийт даатгалын хураамж болон нөхөн төлбөрт эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэхээр зорьж байна.

Бидний сэргээгдэх эрчим хүчний чиглэлээрх харилцагч компаниудын нэг төлөөллийн байгаль орчинд үзүүлж буй нэг жилийн эерэг нөлөөллийг дурдвал:

122,000 тн

түүхий нүүрсний
хэмнэлт

1.6 сая тн

цэвэр усны
хэмнэлт

180,000 тн

хүлэмжийн хийн
ялгарлын бууралт



Даатгалын нөхөн төлбөр

Манай компани нь нийгмийн амар тайван байдал, хүний эрхийн эсрэг чиглэсэн аливаа үйл ажиллагаа, тохиолдлуудыг эсэргүүцэж, хөхүүлэн дэмжихгүй байхад анхааран ажилладаг бөгөөд үүнтэй холбоотойгоор даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзах заалтыг журамласан байдаг. Жишээг дурдвал:

Байлдааны зэвсэг хэрэглэх, атомын, цөмийн болон цацраг идэвхт эрсдэлүүдээс үүссэн хохирол

Ажил хаялт, нийгмийн эмх замбараагүй байдал, иргэний бослого, үймээн, гэмт халдлага

Дайн, хувьсгал, маргаан булаан эзлэх, барьцаалах, баривчлан саатуулах, тэсрэх бөмбөг дэлбэрэх, террорист

Улс төрийн шинж чанартай үйл ажиллагааны улмаас үүдсэн хохирол

2023 онд тээврийн хэрэгслийн даатгал болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын шийдвэрлэсэн тохиолдол **5,424** буюу **6.7 тэрбум төгрөгийн** нөхөн төлбөрийг олгосон. Үүнээс:

52%

Ард даатгал ХК-ийн хохирол
баталгаажуулалт

48%

Тээврийн Цагдаагийн Албаны
хохирол баталгаажуулалт

Тээврийн хэрэгсэлтэй холбоотой даатгалын нөхөн төлбөрийн тохиолдолд байгууллагын хохирол баталгаажуулалтыг түргэн шуурхай, чанартай болгосноор үйлчилгээний хүрээмжийг нэмэгдүүлэхээс гадна даатгуулагчийн цагийг хэмнэх, төрийн үйлчилгээний ачааллаас хуваалцах гэх мэт эдийн засгийн нөөцийн үр ашиг, хэмнэлтийг бий болгох давуу талууд үүсэж байна.

Даатгалын нөхөн төлбөр

Жижиг, дунд бизнес эрхлэгчид

Ард даатгал ХК нь жижиг, дунд байгууллагуудтай хамтран ажиллаж тухайн бизнесүүдэд тохиолдох боломжтой эрсдэлүүдийг хэрхэн удирдах чиглэлээр зөвлөгөө өгч, даатгалын үйлчилгээгээр ханган ажиллаж байна.

Даатгалын төрлүүдийг ангилан харвал 10.3 тэрбум төгрөгийн үнэлгээтэй барилгын бараа материал, 18.3 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий түрээслэгчийн эд хөрөнгийг даатгалын гэрээгээр аливаа эрсдэлээс хамгаалж байна.

Бөөний болон жижиглэн худалдаа, олон нийтийн үйлчилгээ, барилгын гүйцэтгэгч байгууллагууд болон нийтийн өмнө хариуцлага хүлээж буй хувь хүмүүс зэрэг олон салбар, чиглэлээр даатгалын гэрээний дагуу нөхөн төлбөр олгосон байна. Бизнесийн үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлэх, мөн бусдын эд хөрөнгө, бие махбодод учруулсан аливаа хохирлыг барагдуулахтай холбоотой санхүүгийн эрсдэлийг даатгалын тусламжтайгаар хамгаалалт бий болгох нь жижиг, дунд байгууллагуудын өсөлт, үйл ажиллагаагаа тэлэхэд ихээхэн дэмжлэг үзүүлж буй хэлбэр юм.

Жижиг, дунд байгууллагуудад олгосон нөхөн төлбөрийг даатгалын төрлөөр нь ангилан доор үзүүлэв.

13%

Бараа материалын
даатгал

26%

Бүх төрлийн мэргэжлийн
хариуцлагын даатгал

10%

Орон сууц эзэмшигч,
өмчлөгчдийн
хариуцлагын даатгал

2%

Түрээслэгчийн
хариуцлагын даатгал

48%

Ажиллагчдын
хариуцлагын даатгал

Нөөц сангийн хөрөнгө оруулалт

Даатгалын нөөц сангийн хөрөнгө оруулалтын багцийн дийлэнх хэсгийг банк, санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн эзэлж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд бид хувьцаа, бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг санхүүгийн хэрэгслүүдээр хөрөнгө оруулалтын багцаа илүү төрөлжүүлж байна.

Бид цаашдаа технологи суурьтай бизнесүүд болон үндсэн үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөө үзүүлдэггүй компаниудад хөрөнгө оруулах төлөвлөгөөтэй байна. Мөн хөрөнгө оруулалтын бодлогодоо байгаль орчин, нийгэм, засаглалын шалгуур үзүүлэлтийг оруулж, 2025 он гэхэд нийт багцын 20 хувийг энэхүү шалгуурыг хангасан компанид хөрөнгө оруулахаар зорьж байна.



Тасралтгүй хөгжил, тогтвортой ажлын байр

Даатгалын салбарт 5 - 35 жил ажилласан арвин туршлагатай баг, хамт олон маань бидний хамгийн том үнэ цэн билээ. Байгууллагын зүгээс ажлын байрны уян хатан, хүртээмжтэй, аюулгүй байдлыг хангахаас гадна тэдний тасралтгүй боловсрол, өрсөлдөхүйц цалин, тэтгэмж болон албан тушаал ахих боломжийг бүрдүүлэхэд анхааран ажиллаж байна.



Нийт үндсэн ажилчид

34%

66%

Гүйцэтгэх удирдлага

75%

25%

Дунд болон анхан шатны нэгж

34%

66%



Тасралтгүй хөгжил, тогтвортой ажлын байр

2023 онд байгууллагын ажилтнууд

нийт 222 цагийн

сургалтад хамрагдав.



Мэргэжлийн ур чадвар



Хувь хүний хөгжил



Байгууллагын соёл

Байгууллагын зүгээс ажилтнуудын санхүүгийн хараат бус байдлыг дэмжихэд анхааран дараах тэтгэмж, урамшууллыг бүтэн болон тодорхой хувиар олгож байна. Мөн 2023 оноос цалинтай дадлагажигч хөтөлбөр буюу оюутан, залуусыг Ард даатгал ХК-д цалинтай дадлага хийх боломжийг олгож эхэлсэн.

Эрүүл
мэндийн
даатгал

Гэнэтийн
ослын
даатгал


Тэтгэврийн
хуримтлал

Хувьцааны
урамшуулал



Үнэ цэнтэй хөрөнгө оруулалт

Ард даатгал ХК нь 2018 онд Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани болсноос хойш хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хамгаалах, хөрөнгө оруулалтын үнэ цэнийг бий болгохоор хичээнгүйлэн ажиллаж ирсэн билээ. Компанийн тогтвортой ногдол ашгийн бодлогын хүрээнд 2018 оноос хойш хувьцаа эзэмшигчдэдээ мөнгөн болон бусад хэлбэрийн ногдол ашиг олгож ирсэн.



ИТГЭМЖИТ ТҮНШ

Бид бизнесийн бүхий л үйл ажиллагаандаа хамтын ажиллагааг эрхэмлэж, дотоод гадаадын олон салбарын хувь хүн болон байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал, дэд бүтэц, зам тээвэр, иргэний нисэх, агаарын тээвэр, барилга угсралт, үл хөдлөх хөрөнгө, эрчим хүч, уул уурхай газрын тос, хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээ, хөнгөн ба хүнд үйлдвэрлэл, батлан хамгаалах, банк санхүү, аялал жуулчлал, эрүүл мэнд, мэдээлэл технологи, харилцаа холбоо, төрийн ба төрийн бус, олон нийтийн байгууллагууд, эрдэм шинжилгээ, боловсрол, хууль эрхзүй, олон улсын байгууллага, Элчин сайдын яам гэх мэт бүхий л салбаруудад хүрч ажиллажээ.

Бид цаашид тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дотоод болон гадаадын байгууллагуудтай хамтран ажиллаж, байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлээр хэрэгжүүлж буй ажлуудаа илүү боловсронгуй болгохоор төлөвлөж байна.

+220

Төрийн
байгууллагууд

80%

ҮХАҮТ-аас эрэмбэлдэг
ТОП-100 компани

+70

Даатгалын зуучлагчид
болон байгууллага

+20

Давхар даатгалын
компани

+330k

Эрүүл мэндийн
даатгалын гэрээт
сүлжээ эмнэлгүүд






04 Засаглал

Компанийн засаглал

Ёс зүй ба комплаенс

Эрсдэлийн удирдлага

Мэдээллийн аюулгүй байдал



Ард даатгал ХК нь компанийн засаглалын хүрээнд хяналт, хариуцлага, ил тод байдлыг эрхэмлэхээс гадна компанийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар явуулахад чиглэдэг. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь салбартаа мэргэшсэн, оновчтой шийдвэр гаргалт, манлайлалтай удирдлагаар хангахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хамгаалах, урт хугацааны өгөөжийг бий болгоход дэмжин ажилладаг.

Төлөөлөн Удирдах Зөвлөл

- Тогтвортой хөгжлийн чиглэлээр компанийн стратеги, төлөвлөгөөнд хяналт тавьж, чиглүүлэн ажиллаж байна.
- 9 гишүүнтэй ба үүнээс 33%-ийг хараат бус гишүүд эзэлдэг.
- Нийт гишүүдийн 33.3%-ийг эмэгтэй гишүүд эзэлдэг.

Гүйцэтгэх Удирдлага

- Компанийн хэрэгжүүлж буй тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг шууд удирдлагаар хангана.
- Тогтвортой хөгжлийн тайлан бэлтгэх, мэдээллийн урсгалыг удирдана.

Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо

- Тогтвортой байдал, засаглалын асуудалтай холбоотой асуудлуудыг Удирдах зөвлөлд тайлагнана.
- Тогтвортой хөгжлийн чиглэлээр санал, санаачилга гаргаж буй ажилтнуудыг урамшуулах бодлого тодорхойлно.

Санхүү, Эрсдэл, Хөрөнгө оруулалтын хороо

- Даатгалын андеррайтинг, нөхөн төлбөр, бүтээгдэхүүн хөгжүүлэлт зэрэг үндсэн үйл ажиллагааны хүрээнд тогтвортой хөгжил болон байгаль орчин, нийгэмд эергээр нөлөөлөх ажлуудыг зохион байгуулна.
- 2025 он гэхэд Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт, эрсдэлийн үнэлгээний аргачлалд БОНЗ-ын шалгуур үзүүлэлтийг бүрэн тусгахаар ажиллаж байна.

Аудитын хороо

- Компанийн нягтлан бодох бүртгэл болон бүхий л үйл ажиллагааны тайлагналын үнэн зөв байдал холбогдох хууль, дүрэмд нийцтэй байгаа зэрэгт хяналт тавьж, ТУЗ-ийг хяналтын үүргээ биелүүлэх нөхцөлөөр хангаж ажилладаг.
- Тогтвортой хөгжлийн тайланд тусгагдсан тоо мэдээлэл, өгөгдлийн үнэн, зөв, найдвартай байдалд хяналт тавьна.

Ёс зүйн дүрэм

Компанийн удирдлага болон бүхий л ажилтнууд албан үүргээ гүйцэтгэхдээ хууль дээдлэх зарчмаас гадна 2015 онд Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан байгууллагын “Ёс Зүйн дүрэм”-д тусгагдсан дараах хэм хэмжээг баримтлан ажилладаг.



Шударга, зарчимч байх



Хариуцлагатай байх



Даатгуулагч, харилцагч байгууллага, хувь хүний нууцийг чанд хадгалах



Хараат бус байж, гаднын нөлөөнд үл автах

Авлигын эсрэг бодлого

Авлигын шинж чанартай аливаа үйлдлээс ангид байхыг өдөр тутмын үйл ажиллагаандаа анхааран ажилладаг бөгөөд дараах үйлдлүүдийг гаргахыг хориглодог.

- Албан тушаалын давуу байдлаа ашиглах, бусдад давуу байдал олгох, өөрт шан харамж авах, бусдыг дарамтлах, гүтгэх
- Хувьдаа материаллаг болон бусад ашиг хонжоо олох зорилгоор албан тушаалын байдал, боломжоо ашиглах, хэн нэгэнд хууль бус шаардлага тулгах
- Хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг, албан бичиг баримтыг хуурамчаар хэрэглэх, хууль бусаар үйлдэх
- Удирдах ажилтан нь бүх ажилтанд шударга, эрх тэгш хандах зарчим баримтлах бөгөөд аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах, заримыг нь хэт дөвийлгөн сайшаах, онцгой анхаарал хандуулах, эсвэл дорд үзэх

Комплайнсын бодлого

Компанийн хэмжээнд харилцагч байгууллага болон хувь хүмүүстэй бизнес харилцаа тогтоох, даатгал хийх, бүртгэх, төлбөр тооцоо гүйцэтгэх, түүнчлэн бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх зэрэг бүхий л үйл ажиллагаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцтэй, аливаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, зэвсэг дэлгэрүүлэх гэх мэт үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлж, ангид байхыг эрмэлзэн ажиллаж байна.

Үүний дагуу 2022 оны 12 сарын 15-нд компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс “Ард даатгал ХК-ийн Мөнгө угаах, терроризмтой тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр”-ийг батлан өнөөдрийг хүртэл хэрэгжүүлж байна.



Эрсдэлд суурилсан шийдвэр гаргалт

Манай компани нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг болон даатгуулагчийн өмнө хүлээсэн хариуцлагын хүрээнд эрсдэлийн удирдлагын оновчтой бодлогыг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Эрсдэлийг эрт илрүүлэх, үнэлэх, бууруулах
- Боломжит эрсдэлийг хүлээн авах
- Эрсдэлд суурилсан хөрөнгийн үнэлгээ тооцох
- Төлбөрийн чадварын үнэлгээ хийх
- Хохиролд суурилсан эрсдэлийн шинжилгээ хийх зэрэг.

Мөн бид даатгуулагчид, харилцагчдын даатгалын зүйлийн эрсдэлийн үнэлгээг хийж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран эрсдэлийг бууруулах заавар зөвлөгөө, зөвлөмжийг өгч ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд дунджаар 400 гаруй эрсдэлийн удирдлагын чиглэлээр уулзалт, сургалтыг зохион байгуулав.

Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийн хүрээнд “Эрсдэлийн тайлан” болон “Төлбөрийн чадварын үнэлгээний тайлан”-г тус тус боловсруулан өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ашигладаг.

Онцгой байдлын ерөнхий газар болон даатгуулагчидтайгаа хамтран:

- Гамшгаас хамгаалах дадлага сургууль
- Гал унтраах тактикийн сургууль
- Гамшгаас хамгаалах тэнхимийн сургалт
- Гамшгаас хамгаалах нэгдсэн дадлага зэрэг сургалтыг системтэйгээр зохион байгуулж ажилладаг.

Мөн даатгалын эрсдэлүүдтэй уялдан цаг агаарын нөхцөл байдал, гамшигт үзэгдлүүдийг урьдчилан сэрэмжлүүлэх ажлуудыг өөрсдийн цахим сувгууд, үүрэн холбооны хэрэгслээр мессеж явуулах зэргээр ОБЕГ-тай хамтран ажиллаж байна.

Мэдээллийн аюулгүй байдал

2020 оноос эхлэн Ард аппликейшн болон ERP программуудын сервер нь “I Tools” дата төвд байршдаг болж улмаар олон улсын TIER II стандартын дагуу харилцагчийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалан ажиллаж байна. 2-р түвшний дата төв нь нөөц генератор, нөөц хөргөлтийн төхөөрөмжтэй байдаг ч цахилгааны үндсэн шугам болон хөргөлтийг түгээх шугам нь дан шийдэлтэй байдаг тул эрсдэл өндөр хэмээн үзэн жилийн бодит тасалдал 22 цаг буюу жилийн найдвартай ажиллагаа 99.7 хувь байдаг.



Байгууллагын чанарын удирдлагын тогтолцоо



Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо



Мэдээллийн технологийн дэд бүтцийн удирдлага



Мэдээллийн технологийн дэд бүтцийн хяналтын тогтолцоо



Найдвартай сервер бүхий вебийн удирдлагын платформ



05 Хавсралт

SASB удирдамж

НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн зорилгууд

БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж



Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл /SASB/ - Даатгалын стандарт

Сэдэв	Код/Үзүүлэлтүүд	Тайлбар
Хэрэглэгчдэд зориулсан ил тод мэдээлэл, шударга зөвлөгөө	FN-IN-270a.1: Даатгалын бүтээгдэхүүнтэй холбоотой мэдээллийг шинэ болон хуучин хэрэглэгчдэд хүргэх, зах зээлд нэвтрүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны үр дүнд учирсан нийт хохирлын хэмжээ	2023 онд даатгалын нөхөн төлбөртэй холбоотой 3 гомдол ирсэн ба нийт 8,822 нэхэмжлэлд нөхөн төлбөр олгосон байна.
	FN-IN-270a.2: Гомдол, нөхөн төлбөрийн харьцаа	Гомдол, нөхөн төлбөрийн харьцаа = 0.03%
	FN-IN-270a.3: Хэрэглэгчийг хадгалах түвшин	Бусад холбогдох мэдээллийг гаргахаар ажиллаж байна.
	FN-IN-270a.4: Бүтээгдэхүүний талаар хэрэглэгчдэд мэдээлэх арга	Олон нийтэд даатгалын мэдлэг олгох сургалт орохоос гадна байгууллагуудад бүтээгдэхүүний танилцуулга хийх, цахим сувгуудаар мэдээлэл хүргэх гэх мэт арга хэрэгслийг ашиглаж байна.
Хөрөнгө оруулалтын удирдлагад байгаль орчин, нийгэм, засаглалын хүчин зүйлсийг тусгах	FN-IN-410a.1: Салбар болон хөрөнгийн ангиллаар хөрөнгө оруулсан нийт хөрөнгө	Дэлгэрэнгүйг Нийгэм - Хариуцлагатай даатгагч хэсгээс харна уу.
	FN-IN-410a.2: Хөрөнгө оруулалтын удирдлагын үйл явц, стратегид байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) хүчин зүйлсийг тусгах	
Хариуцлагатай зан төлвийг төлөвшүүлэхэд чиглэсэн бодлого	FN-IN-410b.1: Эрчим хүчний хэмнэлт, нүүрстөрөгч багатай, технологийн шийдэлтэй холбоотой цэвэр хураамж	Монголын анхны хувийн хөрөнгө оруулалттай сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр болох Салхит салхин цахилгаан станц (ССЦС)-ыг барьж ашиглалтад оруулсан сэргээгдэх эрчим хүчний Клин Энержи ХХК-ийг сүүлийн 4 жилийн турш даатгаж, жил бүр 415 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий хөрөнгийг хариуцлагын даатгалаар даатгаж байна. Дэлгэрэнгүйг Нийгэм - Хариуцлагатай даатгагч хэсгээс харна уу.
	FN-IN-410b.2: Эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа, зан төлөв ба бүтээгдэхүүний онцлог шинж чанаруудын талаарх бодлого	Дэлгэрэнгүйг Байгаль орчин ба Нийгэм - Хариуцлагатай даатгагч бүлгийн Даатгалын бүтээгдэхүүн хөгжүүлэлт хэсгээс харна уу.

Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл /SASB/ - Даатгалын стандарт

Сэдэв	Код/Үзүүлэлтүүд	Тайлбар
Байгаль орчны эрсдэлд өртөх	FN-IN-450a.1: Даатгалд хамрагдсан бүтээгдэхүүний байгаль цаг уураас шалтгаалж болзошгүй хамгийн их алдагдал (PML)	Энэхүү мэдээллийг гаргахаар ажиллаж байна.
	FN-IN-450a.2: (1) загварчлагдсан байгалийн гамшиг, (2) загварчлаагүй байгалийн гамшиг, үйл явдлын төрөл, газарзүйн сегментээр (давхар даатгалын цэвэр ба нийт) даатгалын нөхөн төлбөртэй холбоотой мөнгөн хохирлын нийт дүн	Дэлгэрэнгүйг Байгаль орчин хэсгээс харна уу.
	FN-IN-450a.3: Байгаль орчны эрсдэлийг (1) андеррайтерийн үйл явц, (2) компанийн түвшний эрсдэл ба хөрөнгийн хүрэлцээний удирдлагад тусгах	Дэлгэрэнгүйг Байгаль орчин - Уур амьсгалын эрсдэлүүд хэсгээс харна уу.
Системчилсэн эрсдэлийн удирдлага	FN-IN-550a.1: Санхүүгийн үүсмэл хэрэгслийн эрсдэл ангилаллаар: (1) төвлөрсөн бус төлбөр тооцоогүй санхүүгийн үүсмэл хэрэгслийн нийт эрсдэл, (2) Төвлөрсөн төлбөр тооцооны төвд байршуулсан хүлээн зөвшөөрөгдөх барьцаа хөрөнгийн нийт бодит үнэ цэнэ, (3) төвлөрсөн төлбөр тооцоогүй үүсмэл хөрөнгийн нийт эрсдэл	Энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаггүй.
	FN-IN-550a.2: Зээлийн барьцаа хөрөнгийн нийт бодит үнэ цэнэ	Энэхүү мэдээллийг гаргахаар ажиллаж байна.
	FN-IN-550a.3: Даатгалын бус системийн үйл ажиллагаатай холбоотой хөрөнгийн болон хөрвөх чадвартай холбоотой эрсдэлийг удирдах арга барил	Ард даатгал ХК-ийн “Эрсдэлийн удирдлагын бодлогын бичиг баримт”-д макро эдийн засгийн эрсдэлийг авч үзсэн байдаг. Эрсдэлийн удирдлагын газар нь стресс тестийг жилд дор хаяж нэг удаа хийж компанийн санхүүгийн байдалд макро эдийн засаг хэрхэн нөлөөлөх таамаг болон цаашид авах арга хэмжээний саналыг бэлтгэн ажилладаг.

Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл /SASB/ - Хөрөнгийн удирдлага ба кастодионы үйл ажиллагааны стандарт

Сэдэв	Хэмжих	Тайлбар
Засаглал /Уур амьсгалын эрсдэл, боломжууд ба байгууллагын засаглалын уялдаа холбоо/	Уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудын талаар Удирдах зөвлөлийн хяналт	Хяналтын тогтолцоог бүрдүүлэхээр ажиллаж байна.
	Уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудыг үнэлэх, удирдах удирдлагын гүйцэтгэх үүрэг	Дэлгэрэнгүйг Засаглал - Компанийн засаглал хэсгээс харна уу.
Стратеги /Байгууллагын бизнес, стратеги, санхүүгийн төлөвлөлтөд уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудын бодит болон боломжит нөлөөллийг ил тод болгох/	Байгууллагын богино, дунд, урт хугацаанд тодорхойлсон уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудын нөлөөлөл	Дэлгэрэнгүйг Тогтвортой хөгжил - БОНЗ-ын тогтолцоо хэсгээс харна уу.
	Байгууллагын бизнес, стратеги, санхүүгийн төлөвлөлтөд уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудын нөлөөлөл	Дэлгэрэнгүйг Тогтвортой хөгжил - Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал хэсгээс харна уу.
	Уур амьсгалтай холбоотой асуудлыг шийдэх арга, тухайлбал 2 градусаар бууруулах зэргийг харгалзан байгууллагын стратегийн тогтвортой байдлыг тайлбарлах	Энэхүү мэдээллийг гаргахаар ажиллаж байна.
Эрсдэлийн удирдлага /Байгууллага уур амьсгалтай холбоотой эрсдлийг хэрхэн тодорхойлж, үнэлж, удирддаг талаар тодруулах/	Уур амьсгалтай холбоотой эрсдэлийг тодорхойлох, үнэлэх байгууллагын үйл явц	Энэ мэдээллийг одоогоор гаргах боломжгүй байна.
	Уур амьсгалтай холбоотой эрсдэлийг удирдах байгууллагын үйл явц	
Хэмжилт ба Зорилтот үзүүлэлтүүд /Уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудыг үнэлэх, удирдахад ашигласан хэмжүүр, зорилтуудыг тодруулах/	Уур амьсгалтай холбоотой эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах үйл явц нь байгууллагын ерөнхий эрсдэлийн удирдлагад хэрхэн нэгтгэгдэж байгааг тайлбарлах	Энэ мэдээллийг одоогоор гаргах боломжгүй байна.
	Байгууллагын стратеги болон эрсдэлийн удирдлагын үйл явцтай уялдуулан уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжийг үнэлэхэд ашигладаг хэмжүүрүүдийг тодруулах	
	Хамрах хүрээ 1, Хамрах хүрээ 2, шаардлагатай бол 3-р хамрах хүрээний хүлэмжийн хийн ялгарал болон холбогдох эрсдэлийг тодруулах	
	Байгууллагын уур амьсгалтай холбоотой эрсдэл, боломжуудыг удирдахад ашигладаг зорилтууд болон зорилтот үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийг тайлбарлах	

БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Үзүүлэлт, хэмжих нэгж	Тайлбар
MS	Тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцооны шалгуур үзүүлэлтүүд				
MS1.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх	Үгүй	
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх	Үгүй	
MS2.2			Тогтвортой хөгжлийн журам байдаг эсэх	Үгүй	
MS3.1		Бүтэц удирдлага	Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх	Үгүй	
MS3.2			ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/ хавсран) байдаг эсэх	Үгүй	
MS3.3			Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан менежер (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Үгүй	
MS3.4			Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Үгүй	
MS3.5			Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тогтмол тусгадаг уу?	Үгүй	
MS4.1		Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн процесс, үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх	Үгүй	
MS5.1		Чадавх бүрдүүлэлт	Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр	10 цаг	
MS6.1	Хяналт	Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?	Тийм	Дэлгэрэнгүйг Засаглал - Компанийн засаглал хэсгээс харна уу.	
MS7.1	Тогтвортой байдлын тайлагнал	Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу?	Тийм		
MS7.2		Танай компани уур амьсгалын эрсдэлийг олон улсын стандарт (УАӨСМТАХ, БОТСМТАХ)-ын дагуу тайлагнадаг уу?	Тийм	Дэлгэрэнгүйг Танилцуулга - Тайлангийн тухай хэсгээс харна уу.	
MS7.3		Тогтвортой хөгжлийн болон БОНЗ-ын мэдээллийг хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулдаг уу?	Үгүй		
MS8.1	Гишүүнчлэл, хамтын ажиллагаа	Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу? Үүнд, хүний эрх болон бизнесийн тунхаглал орно.	Үгүй		

БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Үзүүлэлт, хэмжих нэгж	Тайлбар
Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд					
E1.1	Эрчим хүч	Нийт эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал	кВт, төгрөг	2023 оны байдлаар 29559.99 кВт.ц- 7,894,562
E1.2		Цахилгаан	Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	-	Эдгээр үзүүлэлтүүдийг одоогоор гаргах боломжгүй байна.
E1.3		Дулаан	Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	-	
E1.4		Түлш	Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр). Үүнд, 1. Халаах зорилгоор хэрэглэсэн түл буюу нүүрс, хий 2. Тээврийн зардалд ашигласан түлш буюу бензин, дизель	Литр/кг & %, ГЖоуль, Төгрөг	
E1.5		Хүрэн эрчим хүч	СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь	-	
E1.6		Сэргээгдэх эрчим хүч	СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь	-	
E2.1	Хүлэмжийн хийн ялгарал	3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн	183.6 тн	
E2.2		3.2 Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)	-	
E2.3		3.3 Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гадны төслийг дэмжих гэх мэт) бууралт	150 гаруй мод суулгасан	
E3.1	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?	Үгүй	Энхүү үзүүлэлтийг гаргахаар ажиллаж байна.
E3.2		Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү? (сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)	Үгүй	
E3.3		Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ	Үгүй	
E3.4		Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн	Тийм	
E3.5		Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/ алхмуудыг тодорхойлсон уу?	Үгүй	

БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Үзүүлэлт, хэмжих нэгж	Тайлбар
Е Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд					
E4.1	Ус	Усны хэрэглээ	Ашигласан усны нийт хэмжээ	-	Эдгээр үзүүлэлтүүдийг одоогоор гаргах боломжгүй байна.
E4.2		Хэмнэсэн ус	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ	-	
E4.3		Дахин боловсруулсан ус	Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь	-	
E4.4		Хаягдал бохир ус цэвэрлэх	Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ	-	
E5.1	Хатуу хог хаягдал	Хог хаягдал	Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ		2023 онд нийт 3600кг хог хаягдал ялгаруулсан байна.
E5.2		Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь	-	
E5.3		Хортой хог хаягдал	Хортой хог хаягдлын нийт хэмжээ (Үүнд цахилгаан хэрэгслийн хог орно)		2023 онд 280-290 ширхэг зай, 18 ширхэг принтерийн хор ашигласан. Дэлгэрэнгүйг Байгаль орчин - Бидний хариуцлага хэсгээс харна уу.
E6.1	Биологийн олон янз байдал	Ногоон байгууламж, төлөвлөлт	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь	Байхгүй	
E6.2		Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	Хамгаалсан төрөл зүйлийн тоо	Байхгүй	
E6.3		Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж буй үйл ажиллагаа	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээсэлсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь	Байхгүй	

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Үзүүлэлт, хэмжих нэгж	Тайлбар
S	Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд				
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	0.28%	
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	1 график дизайнер	
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг	159 цаг	
S2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)	ХАБЭА-н бодлого	ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	ХҮАДЖ-д холбогдох заалтууд орсон.
S2.2		Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын хувь	0%	Дэлгэрэнгүйг Нийгэм - Хариуцлагатай ажил олгогч хэсгээс харна уу.
S2.3		ХАБЭА-н сургалт	Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг	12 цаг	
S2.4		Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр	95 хүн	
S3.1	Эрх тэгш байдал	Жендерийн бодлого, журам	Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Үгүй	
S3.2		Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	ХҮАДЖ-д холбогдох заалтууд орсон
S3.3		Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	ХҮАДЖ-д холбогдох заалтууд орсон
S3.4		Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	Эр-33%, Эм-66%	Дэлгэрэнгүйг Нийгэм - Хариуцлагатай ажил олгогч хэсгээс харна уу.
S3.5		Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр - 66.6%, Эм - 33.3%	Дэлгэрэнгүйг Засаглал - Компанийн засаглал хэсгээс харна уу.
S3.6		Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр - 75%, Эм-25%	Дэлгэрэнгүйг Нийгэм - Хариуцлагатай ажил олгогч хэсгээс харна уу.
S3.7		Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр - 34%, Эм-66%	
S3.8		Жендерт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	харьцаа	

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Үзүүлэлт, хэмжих нэгж	Тайлбар
S	Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд				
S4.1	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан олон нийтэд нээлттэй бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	ХҮАДЖ-д холбогдох заалтууд орсон
S4.2		Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь	0.03%	
S4.3		Оффисын хүртээмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу	Тийм	
S4.4		Торгууль	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүйн улмаас төлсөн торгуулийн хэмжээ	Байхгүй	
S5.1	Нийгмийн хариуцлага ба олон нийтийн оролцоо	Оролцогч талуудын оролцооны засаглал	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?	Тийм	
S5.2		Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана)	Үгүй	
S5.3		Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/ журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?	Тийм	Дэлгэрэнгүйг Засаглал - Комплаенсын бодлого хэсгээс харна уу.
S5.4		Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?	Тийм	
S5.5		Ажилчид/олон нийтийн санал гомдол	Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэсэн хувь	2 дахин буурсан	
S5.6		Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт	Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь, ТХЗ-оор ангилсан	-	Дэлгэрэнгүйг Нийгэм - Нөөц сангийн хөрөнгө оруулалт хэсгээс харна уу.
S6.1	Тогтвортой өртгийн сүлжээний менежмент	Худалдан авалтын бодлого, журам	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Үгүй	
S6.2		Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь	-	
S6.3		Тогтвортой, ногоон худалдан авалт	Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь	Байхгүй	

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Үзүүлэлт, хэмжих нэгж	Тайлбар
G	Засаглалын шалгуур үзүүлэлтүүд				
G1.1	Компанийн засаглал	Компанийн засаглалын бодлого, журам	Шинээр батлагдсан Кодексийн дагуу компанийн засаглалын бодлого, журам бий юу, уг журмын тайлагнал хийдэг үү?	Тийм	Дэлгэрэнгүйг Засаглал - Компанийн засаглал хэсгээс харна уу.
G1.2		Удирдах зөвлөлийн хараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь	33%	
G1.3		Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?	Тийм	
G2.1	Авлигал болон ёс зүй	Авлига, хээл хахуулийн эсрэг бодлого журам	Авлигын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?	Тийм	Дэлгэрэнгүйг Засаглал - Ёс зүйн дүрэм хэсгээс харна уу.
G3.1	Комплаенс	Комплаенсын бодлого	Комплаенсын бодлого, журам бий юу?	Тийм	Дэлгэрэнгүйг Засаглал - Комплаенсын бодлого хэсгээс харна уу.
G3.2		Комплаенсын хөтөлбөр	Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу?	Тийм	